

Хэлэлцэх асуудал:

- Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан түүнд хийгдсэн аудитын дүгнэлтийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
- Ногдол ашиг хуваарилах тухай
- Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон 2020 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах
- Махны захын 380м² талбай, авто зогсоол байгуулах, банкны гадна талд засвар хийх түүнд шаардалагтай төсөв санхүүг батлах.

Уг асуудлуудаас гадна хэлэлцэх асуудал байвал саналаа хэлнэ үү.

Толлогын комиссын дарга Д.Тунгалагтуул: тооллогын комиссын анхдугаар тогтоолыг танилцуулав. Тооллогын комисс хэлэлцэх асуудалд санал хураахад 100% саналтай байна

Асуулт хариулт:

- ТУЗ-ийн дарга Ц.Шинэбадам: ТУЗ-ын хурлаас гарсан шийдвэрийг танилцуулав.
- Ц.Содхүү ТУЗ-н гишүүн: Компанийн удирдлагууд эдийн засгийн хэлбэлзэлийг яаж даван туулах цаашид үйл ажиллагаагаа өргөтгөх ашиг орлого нэмэгдүүлэх тал дээр ямар төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна
- ТУЗ-ийн гишүүн Д.Шинэбаяр: Энэ жил Махны захыг засварт оруулах мөн авто зогсоол байгуулах, банкны гадна талд засвар хийх төлөвлөгөөтэй байгаа. Тиймээс бид компанийхаа санхүүгийн чадавхийг улам бүр нэмэгдүүлэх үүднээс ногдол ашиг хуваарилахгүй байхаар санал оруулж байна.
- Н.Намсрайжав: ТУЗ-н гишүүн: Махны захын зааланд засвар хийхэд хөрөнгө санхүүгээ яаж шийдэх вэ. Зээл авах шаардлага байна уу?
- ТУЗ-ийн гишүүн Д. Шинэбаяр: Уг засварууд хийхэд зээл авах шаардлага байхгүй байх гэж бодож байна. Өмнө нь дурдсанаар ноогдол ашигаа тараахгүйгээр засварын ажилаа хийхэд өөр шаардагдах зүйл байхгүй гэж бодож байна.
- Шинэбадам: Компанийн 2019 оны ноогдол ашгийг махны захын засварт хөрөнгө оруулалтад зарцуулах тул ноогдол ашгийг тараахгүй байхаар ТУЗ шийдвэрлэсэнийг танилцуулав.
- Д.Эрдэнэболд, Н.Намсрайжав нар: Компани засвар өргөтгөлийн ажил байнга хийгдэж байгаа тул ноогдох ашиг тараахгүй байх асуудлыг хүлээн зөвшөөрч байна.
- Тооллогын комиссын дарга Д.Тунгалагтуул: Гишүүдийн саналыг илээр хурааж Тооллогын комиссын 03 тоот тогтоолыг танилцуулав.
- Шинэбадам: Компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг танилцуулав.
- Билгүүн: 2020 оны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нарт үүрэг болгож байна.

- Д.Шинэбаяр: Бизнес төлөвлөгөөний талаарх ярилцах асуудал байхгүй бол саналаа хураагаад дараагын асуудалдаа орох уу.

Шийдвэрлэсэн нь:

Д.Шинэбаяр хурлаас гаргах тогтоолыг төслөө танилцуулна уу.

1-р тогтоолын төслийг танилцуулав. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийн тухай Хувьцаа эзэмшигчдийн санал авахад 100% -ийн саналаар батлав.

2-р тогтоолын төслийг танилцуулав. Компанийн ноогдол ашиг тараахгүй байх талаарх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн санал авахад 100%-ийн саналаар батлав.

3-р тогтоолын төслийг танилцуулав 2020 оны бизнес төлөвлөгөөг батлах тухай Хувьцаа эзэмшигчдээс санал авч 100% -ийн саналаар батлав.

Д. Шинэбаяр: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нийт 3 асуудлыг хэлэлцэж 3 тогтоол гаргалаа. Хурал 12 цаг 30 минутанд хааж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай болж өндөрлөлөө.

Хурлын тэмдэглэл хөтлөсөн: Нарийн бичгийн дарга...../Ц.Содхүү/

Хурлын тэмдэглэлтэй танилцсан: Хурлын дарга...../Д.Шинэбаяр/



“ДОРНОД ХУДАЛДАА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

“Дорнод худалдаа” ХК-ний хувьцаа эзэмшигчдийн
хурлын тэмдэглэл

2020.03.30

Чойбалсан хот

Дорнод худалдаа ХК-ний төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны ээлжит хурал “Дорнод худалдаа” ХК-ний байранд 204 тоот өрөөнд 2020 оны 03-р сарын 30-ны өдрийн Даваа гарагийн 10:00 цагт 67.6%-ийн ирцтэйгээр эхлэв.

Хурлаар хэлэлцсэн асуудлыг шийдэж хуралдааныг 12.30 минутанд дуусгав.

Хурлын дарга Д.Шинэбаяр, Тооллогын комиссын дарга Д.Тунгалагтуул гишүүдээр Ц.Содхүү, Н.Намсрайжав нар ажиллав.

Тооллогын комиссын дарга Д.Тунгалагтуул хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэл танилцуулав. Хуралд оролцож буй 49970 ширхэг хувьцаа нь 73969 ширхэг хувьцааны 67.6 хувийг бүрдүүлж байгаа тул хурал хуралдах ирц бүрдсэн болохыг мэдээлэв.

Д.Шинэбаяр: Өнөөдрийн амгаланг айлтгая. Ингээд ээлжит хурлын ирц бүрдсэний дагуу хурлыг эхлэе. Хурлыг даргалаж байгаагийн хувьд хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулан хурлын дэгийг батлах нь зүйтэй. Хурлын дэгийг танилцуулъя.

1	Хурлын ирцийг бүртгэх /тооллогын комисс/	14:00- 14:15
2	Хурлын ирцийн мэдээлэх /тооллогын комисс/	5 минут
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	10 минут
4	Хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	30 минут
5	Асуулт, хариулт, санал шүүмжлэл тавих	30 минут
6	Санал хураалт	20 минут
7	Хурлын засварлага	15 минут
8	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 минут
9	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
10	Хурлыг хаах /хурлын дарга/	5 минут

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэгийг хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналтайгаар батлав.